



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 1612

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн аравдугаар хуралдааны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.9 дэх заалт Худгийн засварын санхүүжилт /Зэрэг сум/ 5,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Зэрэг сумын Засаг дарга /Д.Октябрь/-д шилжүүлсүгэй.



2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 10 дугаар сарын 27-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлтэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 11 дүгээр сарын 20-ны дотор тайлагнахыг Зэрэг сумын Засаг дарга /Д.Октябрь/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ